

**ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН**  
**“НООС” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН**  
**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
/2009 оны жилийн эцсийн байдлаар/

2010.03.05

Д.д	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл						
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо	Хөтөлбөрийг Засгийн газрын 2001.02.11-ний өдрийн 26 дугаар тогтоолоор баталсан.						
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа	2001-2010 он						
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн зорилго нь ноос боловсруулах салбарын эрхэм зорилго, хөгжлийн стратегийн үндсэн чиглэлтэй уялдуулан үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг сайжруулах замаар салбарын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.						
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтуудыг шийдвэрлэнэ: а/ түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдийн аль алинд нь зохимжтой, түүхий эдийн экспортыг бууруулах, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах; б/ үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах; в/ салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх; г/ бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, зах зээлийг өргөжүүлэх.					
		2001-2002 он	Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэлээ хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх.					
		2003-2004 он	Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг тогтвортой нэмэгдүүлэх.					
		2005-2010 он	Ноосон түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, шинээр бий болсон технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээ авч салбарын хөгжлийн стратегийн үндсэн зорилтыг хангах.					
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	10834.7 сая төг					
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Улсын төсвөөс 5.2, ШУТ-ийн сангаас 107.3 сая төг, нийт 112.5 сая төгрөг					
		тухайн жилд зарцуулсан	5.1 сая төг					
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	90	85	75	70	Дундаж оноо
		I-II шатны зорилтын хэрэгжилтийн явц	4	4				90%
		III шатны зорилтын хэрэгжилтийн явц	4		1	1	2	75%

7	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
		Хөтөлбөрийн III шат хэрэгснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:	<u>Үйлдвэрлэлтийн хувьд:</u> - Нэхмэлийн үйлдвэрлэлт 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2006 онд 54, 2007 онд 22, 2008 онд 4.5 хувиар өссөн, 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 хувиар буурч, боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэд 2006 онд
		а/ улсын хэмжээнд байгаа түүхий эдийн нөөцийн ашиглалт 2010 он гэхэд 2000 оныхоос 29.5 хувиар өснө;  б/ ашиглагдаагүй байгаа түүхий эдийг боловсруулах шинэ технологи бий болж, салбарын үйлдвэрүүд хүч чадлаа бүрэн ашиглах нөхцөл бүрдэнэ	27.8 хувь, 2007 онд 23.1 хувь, 2008 онд 19.6, 2009 онд 22.8 хувийг эзэлж байна. 2009 онд салбарын гол бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн гол нэр төрлийг дурдвал ээрсэн утас өнгөрсөн оныхоос 2 дахин, сүлжмэл эдлэл 19.4 хувиар, тэмээний ноосон хөнжил 5.4 хувиар, эсгий, эсгий гутал 48-100 хувиар өссөн, хивс 32 хувиар буурчээ. <u>Экспортын хувьд:</u> - Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 2006 онд 246.7, 2007 онд 262.6, 2008 онд 225.4, 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 192.0 сая ам долл болж 15.2 хувиар буурчээ. - Хонины самнаагүй ноос 2006 онд 6377.9 тн, 2007 онд 9139 тн, 2008 онд 9308 тн, 2009 оны УГ-ээр 5616.7 тн-ыг экспорт-ложээ. - Ноосон ээрмэлийн экспорт биет хэмжээгээр 2007 онд 37.8 тн, 2008 онд 10.7 тн болж 3 дахин буурсан бол үнийн дүнгээрээ 2007 онд 974.5 мян ам долл, 2008 онд 1226.5 мян ам.долл болж 25 хувиар өслөө. Ноосон хувцас, эдлэлийн экспорт 2007 онд 39568.2 мян ам долл, 2008 онд 20517.6 мян ам.долл болж бараг 2 дахин буурч, 2009 оны УГ-ээр 20517.6 мян ам.долл болж бараг 2 дахин буурчээ. <u>Ажиллах хүчний хувьд:</u> - Уг салбарт ажиллагсдын тоо 2006 онд 4799, 2007 онд 5310 болж, 10.6 хувиар өссөн бол 2008 онд 5018 болж 5.5 хувиар, 2009 онд 4174 болж 16.8 хувиар буурчээ. /Санхүүгийн хүндрэлийг даван туулах, зардлаа бууруулах зорилгоор үйлдвэрийн газрууд орон тооны цомцотгол хийсэн, жижиг үйлдвэрүүд зогссон./
8	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа	<p><i>Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, түүхий эдийн экспортыг бууруулах зорилтын хүрээнд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Түүхий эд, бэлтгэлийн чанарын холбогдох стандартыг дахин хянаж, шинэчлэн боловсруулан, ноосон түүхий эдийн тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах арга аргачлалын стандартыг боловсруулан батлуулан мөрдсөн.</li> <li>• “Бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан.</li> <li>• ДБ-ны санхүүжилтээр “Ноос, ноолуурын нэмүү өртгийн гинжин сүлжээ” төсөлтэй хамтран ажиллаж Өвөрхангай аймагт түүхий эдийн чанарыг тодорхойлох лаборатори, ГТХАН-ийн шугамаар хэрэгжиж буй Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Булган, Дархан-уул аймгуудад түүхий эдийн лаборатори, Орхон аймагт Ноос, ноолуурын сургалтын төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмол явуулж байна.</li> </ul>	

	<p><i>Үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах</i> зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах цогцолбор“ төсөл боловсруулсан.</li> <li>• Засгийн газраас баталсан “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д нэхмэл утсыг бэлтгэх сэмлэх самнах туузлах, сунгах, ээрэх үйл ажиллагаа, ноолуур, ноосон, даавуун нэхмэл үйлдвэрлэх, нэхмэл, сүлжмэл хувцас, эдлэл, хивс, хивсэнцэр үйлдвэрлэлийг хамруулж, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж байна.</li> <li>• Засгийн газрын 2009 оны 316 дугаар тогтоолоор баталсан ЖДҮ-ийн үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтанд холбогдох тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хамруулан татвараас чөлөөлж байна.</li> <li>• ЖДҮ-ийг дэмжих зээлийн хүрээнд ноос боловсруулах, эсгий, эсгий гутлын, сүлжмэлийн жижиг үйлдвэрүүдэд зээл олгож байна.</li> </ul> <p><i>Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, үйлдвэрлэл экспортыг нэмэгдүүлэх</i> зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ШУТ-ийн сангийн санхүүжилтээр ноосны гүн боловсруулалт хийх болон шинэ бүтээгдэхүүн хийх технологи боловсруулах төслүүдийг хэрэгжүүлэн, салбарын томоохон үйлдвэрүүдэд нэвтрүүлэв.</li> <li>• Үйлдвэрүүд өөрсдийн хөрөнгөөр самнах цехийн тоног төхөөрөмжөө шинэчлэн, ээрмэл болон ноосон хөнжил үйлдвэрлэдэг шугам суурилуулах, угаах, будгийн цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэн утсаар будах технологи, бүтээгдэхүүний загвар зохион бүтээх орчин үеийн тооцоолон бодох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хүчин чадлаа нэмэгдүүлэн, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нэвтрүүлж байна.</li> </ul> <p><i>Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, зах зээлийг өргөжүүлэх</i> зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хонины ноосны шинж чанарын улсын нэгдсэн ангилал тогтоон, үндэсний стандарт боловсруулав.</li> <li>• Монгол гэрийн эсгийний стандарт, гэрийн бүрээс, хөшигны үндсэн хэмжээний техникийн шаардлага, дулаалгын материалын ерөнхий шаардлага, хивсэнд тавигдах ерөнхий шаардлага, шинжилгээний арга, ээрмэл бүтээгдэхүүн. савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэхэд тавих шаардлага, ээрмэл бүтээгдэхүүн, тэмээний эр ноосон ээрмэл - техникийн шаардлагын стандартуудыг хянаж баталгаажуулсан.</li> <li>• “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандарт батлуулан, мөрдөж байна. “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” MNS 5563:2005 стандартын хэрэгжилтийн байдалд хамтарсан шалгалтыг нийслэлийн 34 аж ахуйн нэгж байгууллагын 110 цехэд хийв.</li> <li>• ШУТ-ийн сангийн санхүүжилтээр “Ширүүн, ширүүвтэр ноосны боловсруулалтын түвшинг сайжруулж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх”, “Тэмээний эр ноосыг бүрэн боловсруулж үйлдвэрлэл техникийн зориулалттай шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулж нэвтрүүлэх” төслүүдийг хэрэгжүүлж байна.</li> <li>• Ноосны ашиглалтыг сайжруулах зорилгоор шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах ажлын хүрээнд Барилгын дулаалга, тусгаарлагч материалын үйлдвэрлэлийн төсөл боловсруулж, Японы талд хүргүүлэн, дэмжигдэж эхний уулзалт хийгдээд байна.</li> <li>• ШУТИС-ын харьяа Нэхмэлийн хүрээлэн дээр загвар зохион бүтээгчдийн давтан сургалт, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн</li> </ul>
--	--

		<p>хүрээлэнд инженерүүдийг мэргэшүүлэх сургалтыг тогтмол явуулж, Монгол-Солонгосын Техникийн коллежид ажлын байрны дадлагаар мэргэжлийн ажилчид бэлтгэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэхмэлийн хүрээлэнгийн лабораторит нано технологийн эхний үе шатны шинэчлэл хийсэн.</li> <li>• Салбарын үйлдвэр, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Монголд үйлдвэрлэв”, “Монгол Ноос ноолуур” үзэсгэлэн, худалдааг сүүлийн 4 жил дараалан зохион байгууллаа.</li> <li>• ОХУ-тай худалдааг либеральчлах хүрээнд тэмээний ноосон цамц, хөнжлийг татвараас чөлөөлөх талаар санал солилцож, ОХУ-аас дэмжихээ илэрхийлжээ. Уг импортын татварын хөнгөлөлтөд хивсийг хамруулах саналыг ОХУ-ын талд тавиад байна.</li> </ul>
9	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.</p> <p>Хөтөлбөрийн 4 зорилтын хүрээнд эхний 2 шатны 2001-2004 онуудад хэрэгжих арга хэмжээний биелэлт 90 хувьтай дүгнэгджээ. Хөтөлбөрийн <b>III үе шатанд /2005-2010 онд/ тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц нь 2009 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай</b> байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон бизнесийн таатай орчин бүрдүүлж эхлээд байна. Гэвч салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, оновчтой хэлбэрээр бүсчлэн хөгжүүлэх, шинжлэх ухаан-технологи-инновацийг эрчимтэй нэвтрүүлэх, урт хугацааны хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хангах, экспортыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээг цогцолбороор шийдвэрлэх шаардлагатай.</p> <p>Салбарын үйлдвэрүүд өөрсдийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж шинэчлэх, үйлдвэрлэлийн шинэ шугамуудыг суурилуулах, шинэ бүтээгдэхүүн хийх технологийг нэвтрүүлэн хүчин чадлаа нэмэгдүүлэн, шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, зах зээлд нийлүүлжээ. Шинэ бүтээгдэхүүнээ олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармагуудад тавьж сурталчлан, 2 бүтээгдэхүүнд чанарын сертификатыг авчээ. Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийн хэрэгцээ шаардлагыг тооцон барилгын зориулалтын техникийн эсгий, дулаалгын материалын үйлдвэрлэлтийг дэмжих нь зүйтэй.</p> <p>Санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү зээллэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц хэмжээгээр буурахгүй, зээлд хамрагдах боломжийг бүрэн олгохгүй байна.</p> <p>Манай сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ, Канад, ОХУ, БНХАУ зэрэг орнуудад экспортлох худалдааны таатай нөхцлийг бүрдүүлэх яриа хэлцэл хийж байгаа ч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Европын холбооны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системийн нэмэлт хөнгөлөлтийн хүрээнд компаниуд Европын холбооны орнуудад сүлжмэл бүтээгдэхүүнээ экспортлох сонирхол байгаа ч тэдний захиалгын тоо хэмжээ бага, стандартынх нь шаардлага өндөр байна. Иймд ноосны чанар, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, гадаадын зах зээлд гаргахад худалдааны хөнгөлөлтийн системийг ашиглах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чухал.</p> <p>Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх, түүхий эдийн экспортыг бууруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байна.</p> <p>“Ноос” дэд хөтөлбөрийн III үе шат 2005 оноос эхэлсэн боловч уг шатны төлөвлөгөө боловсруулан батлуулах ажил хийгдээгүй байна.</p>

		Үр дүнгийн статистик үзүүлэлтийн хувьд сүүлийн жилүүдэд нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт буурсаар байна.
10	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<ul style="list-style-type: none"> <li>- Салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд санхүү, зээл, татвар, даатгалаар дэмжих эрх зүйн орчин бий болсон ч эдгээр үйлчилгээний хүртээмж бага, зээл олгох хүрээ нь хязгаарлагдмал.</li> <li>- Хөтөлбөрийн үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй.</li> </ul>
11	Эдгээрээс гарах арга зам	<ul style="list-style-type: none"> <li>- Монголын ноосны салбарын өнөөгийн байдал, дэлхийн ба дотоодын зах зээлийн эрэлт-нийлүүлэлт, үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа явуулах, салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулах,</li> <li>- Түүхий эдийн бэлтгэл, чанарын хамгаалалт, тээвэрлэлт, нийлүүлэлт, үнийн нэгдсэн системийг бий болгох, түүхий эдийн экспортод хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх,</li> <li>- Ноосны чанарыг сайжруулж, бүдүүвтэр, нарийн, нарийвтар ноост хонины тоо толгойг нэмэгдүүлэх, уг асуудлаар ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төслүүдтэй хамтран ажиллах,</li> <li>- Зах зээлийн хэрэгцээг судлан, техникийн эсгий, барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,</li> <li>- Ноосон бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, гадаадын зах зээлд гаргахад худалдааны хөнгөлөлтийн системийг ашиглах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх,</li> <li>- Ноолуур, ноос боловсруулах цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, энэ ажлын хүрээнд салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг шийдвэрлэх,</li> <li>- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг нь тогтмолжуулах, үе шатны болон оны төлөвлөгөө, тайланг хэлэлцэх, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцан, өгсөн зөвлөмжийг цаашдын ажлын төлөвлөлтөд тусган ажиллах.</li> </ul>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаарх үнэлгээ	Оролцогч талууд хамтран ажилласан. Цаашид салбарын үйлдвэрүүд төсөл хамтран хэрэгжүүлэх, стратегийн чиглэлээр дагнах, нэгдэх замаар хүсэн хүлээсэн үр дүндээ хүрэх, үндэсний ноосны бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчид стратегийн түншлэлийн холбоо тогтоон ашиглах нь зүйтэй.
13	Хөтөлбөрийн талаархи яамны санал	Хөтөлбөрийг хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА